



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/554

Булган сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын үндэсний олон нийтийн радио телевизтэй хамтран Байгаль экологи, танин мэдэхүйн нэвтрүүлгийг Баян-Агт сумын Хануй, Цагаан голын рашаанд зохион байгуулахад 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Санхүүжилтийг Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын Тусгай хамгаалалттай бүсэд байгаа түүх, соёлын дурсгалыг хамгаалах, хөгжүүлэх, сурталчлан таниулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Байгаль хамгаалах сангийн нягтлан бодогч (Э.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.ЛҮРЭВ-ОЧИР